



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

**Зорилтот жилийн ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Багахангай дүүргийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, иргэдийн санал санаачилга, идэвх оролцоог дэмжих, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд 2023 оныг “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгосонтой холбогдуулан ажилчдын ажлын хариуцлага, сахилга бат, чанартай төрийн үйлчилгээг хүргэн ажиллахыг уриалсугай.

2. Зорилтот жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоог хангах, дэмжиж ажиллах чиглэлээр үр дүнд чиглэсэн ажил, ажилчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг чанартай зохион байгуулах, тайланг нэгтгэж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ